

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн, өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН
ТЕАТРЫН ЗАХИРАЛ
Д.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА

2020 02 27 № 06/623
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын драмын эрдмийн театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын драмын эрдмийн театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын драмын эрдмийн театрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Улсын драмын эрдмийн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улсын драмын эрдмийн театрын захирал Д.Цэрэнсамбуу Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн худалдан авах ажиллагаа болон борлуулалтын орлогын талаарх зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын драмын эрдмийн театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын драмын эрдмийн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 2-ноос 2020 оны 2 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын драмын эрдмийн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Баян ташаагийн эх Аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улсын драмын эрдмийн театр нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо мэргэжлийн түвшинд чанартай уран бүтээл туурвиж, ард түмнийг соён гэгээрүүлэх хөтөч нь байна гэж тодорхойлжээ.

Улсын драмын эрдмийн театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний болон дэлхийн сонгодог жүжгүүдээр урын сангаа баяжуулж, үзэгчдэд чиглэсэн менежментийн онцгой бодлоготойгоор урлаг, уран сайхныг сурталчлах, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол;
- Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019 оны 268 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24-р тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 25-р тогтоолоор Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай ;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276-р тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох ;
- Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаал “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын драмын эрдмийн театр нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Ординат” ХХК-ийн Юникус программ хангамж ашиглаж байна.

Улсын драмын эрдмийн театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улсын драмын эрдмийн театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,573,572.0 мянган төгрөгөөс тооцон 15,735.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,349,072.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 23,490.7 мянган төгрөг болж өөрчлөгдсөн нь төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсонтой холбоотой.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улсын драмын эрдмийн театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,359,8 мянган төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	300.9	3.3	(297.6)
Урьдчилгаа			-
Бараа материал	519,511.3	706,477.6	260,364.1
Үндсэн хөрөнгө	7,806,334.2	7,663,025.4	(143,308.7)
Нийт хөрөнгө	8,326,146.5	8,369,506.3	43,359.4
Өр төлбөр	819.8	812.3	(7.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,325,326.6	8,368,694.0	43,367.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,326,146.5	8,369,506.3	43,359.4

Авлага дансны үлдэгдэл буурсан нь урд оны ажилчдаас авах авлага төлөгдсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн бөгөөд үүнээс бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 193,551.7 мянган төгрөгөөр өссөн нь шинэ уран бүтээл туурвихтай холбоотойгоор жижиг хэрэгсэл, туслах материалууд худалдан авсантай холбоотой юм. Тайлант онд 10 уран бүтээл сэргээж, 4 жүжиг шинээр туурвиж үзэгчдийн хүртээл болгосон.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл элэгдлийн зардлаар буурсан байна. Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг үндэслэж 65,444.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 7.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн ашиг 36,067.4 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 7,300.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 7,300.0 мянган төгрөгийн бичилт нь өмнөх оны зөвлөмжөөр үндсэн хөрөнгийг капиталжуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын драмын эрдмийн театр тайлант онд орлого төвлөрүүлэх төлөвлөгөөгүй ажилласан бөгөөд гүйцэтгэлээр 507,647.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогыг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан журмын гуравдугаар хавсралтад заасны дагуу нэмэлт санхүүжилтийн орлогод хуваарилсан.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл урлагийн хөтөлбөрт зориулан 1,783,430.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан, үүнээс 1,770,430.3 мянган төгрөгийг урсгал зардалд, урсгал шилжүүлэгт 13,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар хуваарилсан.

Нийт зардлын 1,783,430.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 507,547.6 мянган төгрөг, Нийслэл гэр, бүл хүүхэд залуучуудыг хөгжлийн газраас 80,000.0 мянган төгрөг, нийт 587,547.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 48,950.0 мянга, хангамж бараа материалын зардалд 9,845.2 мянга, норматив зардалд 4,420.0 мянга, эд хогшил урсгал засварын зардалд 100,498.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 408,960.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 9,996.6 мянга, нийт 587,427.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 120.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж, нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 15,500.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Улсын драмын эрдмийн театрын үндсэн үйл ажиллагааны орлогыг батлагдсан төсөвт тусгагдаагүй байгааг анхаарах гол асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улсын драмын эрдмийн театр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 удаагийн мэдээллийг хуулийн хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,464.1 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоосныг барагдуулсан байна.

Нийт 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын драмын эрдмийн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 15,500.9 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 23,490.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улсын драмын эрдмийн театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасны дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Тайлант онд уран бүтээлийн зардлаас үнийн дүнгийн харьцуулалт хийхгүйгээр 9,900.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсныг шууд худалдан авалт хийх босго үнийг 100.0 мянган төгрөгөөр бууруулж шууд гэрээ хийсэн гэж үзсэн болно.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д "Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл: Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Тоглолтын тасалбарын орлогыг тулган шалгахад борлуулалтын бэлэн мөнгөний орлого 5,600.0 мянган төгрөгийг хуримтлуулан тушаасан, мөн тоглолтын тасалбар худалдаалах зуучлалын гэрээтэй "Гэр медиа" ХХК нь тасалбарын орлогыг зарим сард гэрээт хугацаанаас 5-10 хоногоор хоцроож тушаасан.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3.12-д "...хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж..." гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл: Бэлэн мөнгө дутагдах, гэрээний үүргийн биелэлт хангагдахгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, мөн "Гэр медиа" ХХК-иас билет борлуулалтын орлогыг гэрээний дагуу шаардаж хугацаанд нь тушаалгаж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Орлогын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт: Улсын драмын эрдмийн театрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 507,547.6 мянган төгрөгийн орлого нь төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмын 3.4-т "Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно", 3.4.3-т "үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол шинжтэй орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл: Төсвийг үр ашиггүй зарцуулах.

3.3.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг мөрдөж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	519,812,314.82	706,480,926.14
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	300,960.00	3,334.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,960.00	3,334.32
35	БАРАА МАТЕРИАЛ	519,511,354.82	706,477,591.82
351	Түүхий эд материал	5,370,832.00	3,447,645.00
35110	Тусгай зориулалттай материал	5,370,832.00	3,447,645.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	38,833,927.20	32,439,827.20
354	Хангамжийн материал	475,306,595.62	670,590,119.62
35410	Бичиг хэргийн материал	-	550,500.00
35420	Аж ахуйн материал	474,216,215.62	655,711,989.62
35440	Түлш, шатах тослох материал	-	1,181,250.00
35470	Бусад хангамжийн материал	1,090,380.00	13,146,380.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,806,334,168.04	7,663,025,424.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,806,334,168.04	7,663,025,424.66
392	Биет хөрөнгө	7,368,060,168.04	7,224,751,424.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,277,351,660.00	7,281,751,660.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,971,100.10)	(257,561,003.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,086,865.00	134,986,865.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(111,910,281.89)	(116,739,852.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	845,477,175.46	896,556,081.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(787,461,623.26)	(796,161,218.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	225,948,023.70	264,585,439.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(183,604,147.87)	(193,810,143.91)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	11,143,597.00	11,143,597.00
393	Биет бус хөрөнгө	438,274,000.00	438,274,000.00
39301	Програм хангамж	2,800,000.00	2,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,800,000.00)	(2,800,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	438,274,000.00	438,274,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,326,146,482.86	8,369,506,350.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	819,853.81	812,296.07
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	819,853.81	812,296.07
413	Өглөг	819,853.81	812,296.07
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	819,853.81	812,296.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,325,326,629.05	8,368,694,054.73
51	Засгийн газрын хувь оролцоо	8,325,326,629.05	8,368,694,054.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,589,196,963.73	3,589,196,963.73
51101	Өмч: - төрийн	3,589,196,963.73	3,589,196,963.73
512	Хуримтлагдсан үр дүн	(1,502,833,124.44)	(1,459,465,698.76)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,502,833,124.44)	(1,495,533,124.44)
51220	Тайлант үеийн үр дүн	-	36,067,425.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,238,962,789.76	6,238,962,789.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,326,146,482.86	8,369,506,350.80

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,238,596,470.00	2,385,139,396.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,187,089.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,187,089.00
120003	Торгуулийн орлого	-	1,187,089.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,238,596,470.00	2,383,952,307.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,152,842,080.00	1,796,404,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,147,464,000.00	1,783,430,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	5,378,080.00	12,974,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,754,390.00	587,547,607.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,754,390.00	587,547,607.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,566,271,981.47	2,349,071,970.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,566,271,981.47	2,349,071,970.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,540,868,520.01	2,253,428,414.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	929,287,456.96	1,233,781,537.85
210101	Үндсэн цалин	796,229,851.82	962,768,015.58
210102	Нэмэгдэл	21,216,418.72	192,010,522.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,830,335.27	79,003,000.00
210104	Урамшуулал	41,010,851.15	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,078,505.35	150,765,140.38
210201	Тэтгэврийн даатгал	75,276,085.05	105,801,608.83
210202	Тэтгэмжийн даатгал	7,218,948.51	13,093,313.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,023,685.63	8,934,797.94
210204	Ажилгүйдлийн даатгал	1,804,737.13	2,566,274.48
210205	Эрүүл мэндийн даатгал	14,755,049.03	20,369,145.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,157,642.30	97,928,997.41
210301	Гэрэл, цахилгаан	47,311,849.00	49,027,373.00
210302	Түлш, халаалт	31,908,478.00	34,112,532.38
210303	Цэвэр, бохир ус	12,937,315.30	14,789,092.03
2104	Хангамж, бараа материалын зардал	11,517,999.61	19,397,853.37
210401	Бичиг хэрэг	225,400.00	1,090,270.00
210402	Тээвэр, шатахуун	1,047,000.00	1,065,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,980,003.54	8,144,443.37
210404	Ном, хэвлэл	300,000.00	219,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,257,700.00	7,498,900.00
210408	Бараа материал актальсны зардал	2,707,896.07	1,379,040.00
2105	Нормативт зардал	-	2,935,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,935,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,310,221.00	33,443,400.00
210604	Урсгал засвар	21,310,221.00	33,443,400.00
2107	Томилолт, зочны зардал	14,980,000.00	11,250,000.00
210702	Дотоод албан томилолт	14,980,000.00	11,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	269,634,281.83	450,104,763.26

Улсын драмын эрдмийн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	264,558,681.83	444,426,003.26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,300,000.00	1,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	691,200.00	596,460.00
210807	Газрын төлбөр	1,084,400.00	1,782,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,902,412.96	253,821,722.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,875,000.00	13,496,657.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,027,412.96	240,325,065.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,403,461.46	95,643,555.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	11,590,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	11,590,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,403,461.46	84,053,155.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,403,461.46	84,053,155.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(327,675,511.47)</u>	<u>36,067,425.68</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(327,675,511.47)</u>	<u>36,067,425.68</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,585,839,190.00</u>	<u>2,370,977,907.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	292,620,800.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	292,620,800.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	292,620,800.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	284,620,800.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,293,218,390.00	2,370,977,907.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,147,464,000.00	1,783,430,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,147,464,000.00	1,783,430,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	145,754,390.00	587,547,607.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,754,390.00	587,547,607.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,585,839,190.00</u>	<u>2,305,533,401.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,585,839,190.00	2,305,533,401.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,560,435,728.54	2,209,889,845.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	928,768,563.15	1,232,597,783.17
210101	Үндсэн цалин	842,047,187.00	961,584,260.90
210102	Нэмэгдэл	-	192,010,522.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,146,000.00	79,003,000.00
210104	Урамшуулал	575,376.15	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,078,505.35	150,765,140.38
210201	Тэтгэврийн даатгал	75,276,085.05	105,801,608.83
210202	Тэтгэмжийн даатгал	7,218,948.51	13,093,313.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,023,685.63	8,934,797.94
210204	Ажилгүйдлийн даатгал	1,804,737.13	2,566,274.48
210205	Эрүүл мэндийн даатгал	14,755,049.03	20,369,145.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,157,642.30	97,928,997.41
210301	Гэрэл, цахилгаан	47,311,849.00	49,027,373.00
210302	Түлш, халаалт	31,908,478.00	34,112,532.38
210303	Цэвэр, бохир ус	12,937,315.30	14,789,092.03
2104	Хангамж, бараа материалын зардал	9,654,103.54	21,467,163.37
210401	Бичиг хэрэг	635,400.00	1,640,770.00
210402	Тээвэр, шатахуун	1,047,000.00	2,246,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,980,003.54	8,144,443.37
210404	Ном, хэвлэл	330,000.00	219,700.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,661,700.00	9,215,500.00
2105	Нормативт зардал	3,600,000.00	8,020,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,600,000.00	8,020,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,252,471.00	38,224,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,400,000.00	
210602	Тавилга	-	
210604	Урсгал засвар	35,852,471.00	38,224,400.00
2107	Томилолт, зочны зардал	14,980,000.00	11,250,000.00
210702	Дотоод албан томилолт	14,980,000.00	11,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	347,069,443.20	629,639,704.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	341,993,843.20	623,960,944.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,300,000.00	1,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	691,200.00	596,460.00
210807	Газрын төлбөр	1,084,400.00	1,782,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,875,000.00	19,996,657.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,875,000.00	19,996,657.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,403,461.46	95,643,555.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	11,590,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	11,590,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,403,461.46	83,932,755.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,403,461.46	83,932,755.67
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	120,400.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	120,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>65,444,506.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	65,444,506.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	65,444,506.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		65,444,506.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(65,444,506.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,150,922,963.73	-	(1,520,478,412.97)	1,630,444,550.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	438,274,000.00	-		438,274,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,589,196,963.73	-	(1,520,478,412.97)	2,068,718,550.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	6,238,962,789.76	-	6,238,962,789.76
Тайлант үеийн үр дүн			17,645,288.53	17,645,288.53
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,589,196,963.73	6,238,962,789.76	(1,502,833,124.44)	8,325,326,629.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,300,000.00	7,300,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,589,196,963.73	6,238,962,789.76	(1,495,533,124.44)	8,332,626,629.05
Тайлант үеийн үр дүн			36,067,425.68	36,067,425.68
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,589,196,963.73	6,238,962,789.76	(1,459,465,698.76)	8,368,694,054.73

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,783,430,300.00	1,699,497,544.33	(83,932,755.67)	95.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,783,430,300.00	1,699,497,544.33	(83,932,755.67)	95.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,770,430,300.00	1,687,907,144.33	(82,523,155.67)	95.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,250,896,200.00	1,183,647,783.17	(67,248,416.83)	94.6
Үндсэн цалин	955,244,900.00	912,634,260.90	(42,610,639.10)	95.5
Нэмэгдэл	209,466,100.00	192,010,522.27	(17,455,577.73)	91.7
Унаа хоолны хөнгөлөлт	86,185,200.00	79,003,000.00	(7,182,200.00)	91.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,362,000.00	146,009,690.38	(10,352,309.62)	93.4
Тэтгэврийн даатгал	106,326,200.00	101,046,158.83	(5,280,041.17)	95.0
Тэтгэмжийн даатгал	12,508,900.00	13,093,313.39	584,413.39	104.7
ҮОМШӨ-ний даатгал	10,007,100.00	8,934,797.94	(1,072,302.06)	89.3
Ажилгүйдлийн даатгал	2,501,800.00	2,566,274.48	64,474.48	102.6
Эрүүл мэндийн даатгал	25,018,000.00	20,369,145.74	(4,648,854.26)	81.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,929,000.00	97,928,997.41	(2.59)	100.0
Гэрэл, цахилгаан	33,852,500.00	49,027,373.00	15,174,873.00	144.8
Түлш, халаалт	44,186,500.00	34,112,532.38	(10,073,967.62)	77.2
Цэвэр, бохир ус	19,890,000.00	14,789,092.03	(5,100,907.97)	74.4
Хангамж, бараа материалын зардал	11,828,200.00	11,621,913.37	(206,286.63)	98.3
Бичиг хэрэг	641,400.00	640,770.00	(630.00)	99.9
Тээвэр, шатахуун	1,065,500.00	1,065,500.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,083,600.00	8,144,443.37	60,843.37	100.8
Ном, хэвлэл	376,000.00	219,700.00	(156,300.00)	58.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,661,700.00	1,551,500.00	(110,200.00)	93.4
Нормативт зардал	3,600,000.00	3,600,000.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,600,000.00	3,600,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.00	3,170,000.00	(30,000.00)	99.1
Урсгал засвар	3,200,000.00	3,170,000.00	(30,000.00)	99.1
Томилолт, зочны зардал	15,000,000.00	11,250,000.00	(3,750,000.00)	75.0
Дотоод албан томилолт	15,000,000.00	11,250,000.00	(3,750,000.00)	75.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	221,614,900.00	220,678,760.00	(936,140.00)	99.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	215,000,000.00	215,000,000.00	-	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	1,300,000.00	1,300,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	1,413,800.00	596,460.00	(817,340.00)	42.2
Газрын төлбөр	1,901,100.00	1,782,300.00	(118,800.00)	93.8
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,000,000.00	11,590,400.00	(1,409,600.00)	89.2
Бусад урсгал шилжүүлэг	13,000,000.00	11,590,400.00	(1,409,600.00)	89.2

Улсын драмын эрдмийн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,000,000.00	11,590,400.00	(409,600.00)	96.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-	(1,000,000.00)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,783,430,300.00	1,699,497,544.33	(83,932,755.67)	95.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,783,430,300.00	1,699,497,544.33	(83,932,755.67)	95.3
Улсын төсвөөс санхүүжих	1,783,430,300.00	1,699,497,544.33	(83,932,755.67)	95.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
Төсвийн байгууллага	1	1	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	129	111	-	-
Удирдах ажилтан	1	4	-	-
Гүйцэтгэх ажилтан	101	61	-	-
Үйлчлэх ажилтан	27	46	-	-

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		587,547,607.00
УРСГАЛ ЗАРДАЛ		587,547,607.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		587,427,207.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		48,950,000.00
Үндсэн цалин		48,950,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,755,450.00
Тэтгэврийн даатгал		4,755,450.00
Хангамж, бараа материалын зардал		9,845,250.00
Бичиг хэрэг		1,000,000.00
Тээвэр, шатахуун		1,181,250.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,664,000.00
Нормативт зардал		4,420,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		4,420,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		100,498,906.00
Багаж, техник, хэрэгсэл		38,104,506.00
Тавилга		27,340,000.00
Урсгал засвар		35,054,400.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		408,960,944.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		408,960,944.00
Бараа үйлчилгээний бусад зардал		9,996,657.00
Бараа үйлчилгээний бусад зардал		9,996,657.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		120,400.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		120,400.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		120,400.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		587,547,607.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		587,547,607.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		587,547,607.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.21	Аудитын нэр: 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/141/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Улсын драмын эрдмийн театр	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд уран бүтээлийн зардлаас үнийн дүнгийн харьцуулалт хийхгүйгээр 9,900.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсныг шууд худалдан авалт хийх босго үнийг 100.0 мянган төгрөгөөр бууруулж шууд гэрээ хийсэн гэж үзсэн болно.	9,900.9	Зөвлөмж	УДЭТ-ын захирал, ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэнсамбуу Л.Нина
2	Тоглолтын тасалбарын орлогыг тулган шалгахад борлуулалтын бэлэн мөнгөний орлого 5,600.0 мянган төгрөгийг хуримтлуулан тушаасан, мөн тоглолтын тасалбар худалдаалах зуучлалын гэрээтэй "Гэр медиа" ХХК нь тасалбарын орлогыг зарим сард гэрээт хугацаанаас 5-10 хоногоор хоцроож тушаасан.	5,600.0	Зөвлөмж	УДЭТ-ын захирал, ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэнсамбуу Л.Нина
3.	Улсын драмын эрдмийн театрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 507,547.6 мянган төгрөгийн орлого нь төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.		Зөвлөмж	УДЭТ-ын захирал, ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэнсамбуу Л.Нина
	Дүн	15,500.9			

ТЭМДЭГЛЭЛ

A series of 35 horizontal dotted lines spanning the width of the page, providing space for handwritten text.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

